



93

**УЛААНБААТАР
ХОТЫН АРДЫН ДЕПУТАТУУДЫН
ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ
ТОГТООЛ**

1962-8-2.

дугаар. ¹⁸¹.....

Улаанбаатар хот

Тэнгэр 1990 оны 140 дугаар сурвалж
Архитектурын зөвлөлийн дүрмийг

батлах тухай.

Улаанбаатар хотын АДХ Гүйцэтгэх Захиргаанаас

Т О Г Т О О Х нь.

1. Улаанбаатар хотын Архитектурын газрын дэргэд байгуулагдсан Архитектурын зөвлөлийн дүрмийг баталсугай.

2. Архитектурын зөвлөл байгуулагдсан тухай олон түмэнд хэвлэлээр дамжуулан сурталчлахыг Архитектурын зөвлөлийн дарга н. Чимэдэд даалгасугай.

УЛААНБААТАР ХОТЫН АДХ ГҮЙЦЭТГЭХ

ЗАХИРГААНЫ ДАРГА *Лувсанчоймбол* ЛУВСАНЧОЙМБОЛ

ХАРИУЦЛАГАТАЙ НАРИЙН

БИЧГИЙН ДАРГЫГ

Балжинням
БАЛЖИННЯМ

хянаж зөвшөөрсөн.
боловсруулж нийлсэн.
санал оруулсан.

5% цо. З.в.

Улаанбаатар хотын Архитектурын газрын дэргэдэх

Архитектурын Зөвлөлийн дүрэм.

I. Ерөнхий байдал.

1. Архитектурын зөвлөл нь Улаанбаатар хотын АДХ Гүйцэтгэх Захиргаа ба Улсын Барилга Өмчийн Засгийн Комиссын шийдвэрийн үндсэн дээр байгуулагдана.

2. Архитектурын зөвлөл нь эрдэмтэн, архитектор, инженер, техникийн мэргэжилтэн, элч, зураач, эдийн засагч, барилгачин, олон нийтийн төлөөлөгч зэрэг дээд дунд мэргэжил бүхий хувь хүмүүсүүдээр зохион байгуулагдана. Зөвлөлийн бүрэлдүүн нь Улаанбаатар хотын Гүйцэтгэх Захиргааны бүх гишүүдийн журлаар батлагдана.

3. Архитектурын зөвлөл нь ерөнхий архитектурын газрын дэргэдэх зөвлөл байгууллага болно.

4. Архитектурын зөвлөл нь өөрийн ажилд БНМАУ-ын Засгийн Газраас гери байгаа хууль дүрэм, тогтоол ба Улаанбаатар хотын Гүйцэтгэх Захиргааны шийдвэр мөн архитектурын газрын дүрэм зааврыг удирдлага болгоно.

5. Архитектурын зөвлөл нь өөрийн ажлыг Улаанбаатар хот ба түүний орчин тойрны нутаг дэвсгэрийн дотор явуулна.

2. Энэ зөвлөлийн үүрэг ба гүйцэтгэх асуудал.

6. Архитектурын зөвлөлийн гол үүрэг нь хотыг барилга-жууламт талаар техникийн нэгдмэл бодлого явуулах, хотыг барилгажуулах ба ойн паркийн бүсийг байгуулахад техникийн дэвшилтийг нэвтрүүлэх ба төлөвлөлт барилгажуулалттай холбогдсон чухал асуудлуудыг хэлэлцэнэ.

7. Энэ дүршийн 6-р зүйлд дурьдсан үүргүүдийг гүйцэтгэхийн тулд архитектурын зөвлөл юу хийх вэ?

а/Хотыг барилгажуулах ба ойн паркийн бүсийг байгуулахад техникийн дэвшилтийг нэвтрүүлэх, кэтийн төлөвлөлт, барилгажуулалттай холбогдсон чухал асуудлыг мөн хотын барилгажуулалт техникийн бодлогын чигийг тодорхойлсон зураг төлөвлөгөөнүүлийг хэлэлцэж улмаар Улаанбаатар хотын Гүйцэтгэх Захиргааны хурлаар батлуулах. Үүнд.

1. Улаанбаатар хотын цэцэрлэгүүд, ойн парк хамгаалалтын бүсийг одоо ирээдүйн хөгжилтэй холбогдуулан техник эдийн засгийн үндэслэл зураг төслийг .

2. Орон сууцны районы төлөвлөсөн бүсүүдийн комплекс төсөл, микройон буюу тусгай хороололтын барилгажуулалт гол гудамж талбай тээврийн барилга парк голын зах төхижуулах тэдгээрийг барьж байгуулахад чухал ач холбогдолтой төлөвлөлтийн нэгдсэн төсөл.

3. Хот байгуулахад чухал ач холбогдолтой барилгажуулалтын комплекс барилга байшингийн төслийг.

4. Туршлагын барилгажуулалтын төсөл мөн хойшид үлэмж хэмжээгээр барилгажуулалтыг авуулах үлгэрчилсэн төслийг

5. Хотын гадна талын үзэмж чимэглэл тохижуулалтын төсөл, хот байгуулахад ач холбогдолтой буюу ховор зүйл болон дурсгалын зүйл хөшөө баримал, бонтийн бусад урлагийн зүйлийг архитектуртай уялдуулан тэдний талаар төслийг авч хэлэлцэж батлах.

Б. Хэлэлцэж зөвшөөрсний дараа газрын дарга буюу түүний орлогчид батлуулахаар оруулах үүнд:

-Тусгай хороолол, микрорайон, гудамж, хотын тусгай, заншилгаа, цэцэрлэг, парк бульвар зэрэг газрууд, хэрэв тэд нь өөрийн чанар байдалд ба барилгын талаар а,б заасанд, орохгүй бол тэдний төлөвлөлтийн комплекс төслийг,

-Барилга барих буюу шинэчлэн байгуулах талаар төслийн даалгавар үлгэрчилсэн төсөлд уялдуулсан тодорхой хэсэг газрын төсөл, хэрэв энэ нь өөрийн ач холбогдлын хувьд а-д зааснаар орохгүй бол түүнийг.

в -Хотын гадна талын үзэмж, чимэглэл ба тохижуулалт, хөшөө

Баримал, фондын бусад угсралтын зүйлийг архитектуртай уялдуулах, харав тэд нь өөрийн ач холбогдлын хувьд а-д зааснаар орохгүй бол тэдний төслийн даалгаврыг

В. Хотыг барилгажуулах ба төлөвлөхөд сайн практик барилгын техник ба архитектурыг дэвшилтэйгээр хөгжүүлэхэд чиглэсэн зарим иргэдийн шинэ санаачлага төлөвлөх байгууллагууд, шинжлэх ухааны газруудаар оруулсан саналуудыг шүүмжлэн хэлэлцэнэ.

Г. Хот байгуулах төлөвлөлтийн практикийг дүгнэж түүнд дүн шинжилгээ хийж архитектур-төлөвлөлтийн ба техник эдийн засгийн практикт дэвшилт аргуудыг нэвтрүүлэх зорилгоор архитекторын зөвлөлийн ажлын тухай төлөвлөх байгууллагуудад өргөнөөр мэдээлж байх.

Д. Шинэ социалист үеийн хот болсон Улаанбаатар хотын хөгжилт ба байгуулалтын талаар сурталчимгаа явуулна.

3. Эрх нь:

8. Архитекторын зөвлөлийн эрх нь:

а/Архитекторын зөвлөлөөр хэлэлцэхээр чухлаар шаардагдаж байгаа тооцоо зураг төлөвлөгөө ба бусад бичиг

баригтуудыг барилга барих газар төлөвлөх байгууллагуудаас нэхэмжлэн шаардах эрхтэй.

б/Тус зөвлөлийн хуралд бэлтгэх ба хуралдааны явцын дуудуур шаардлагатай гэж үзвэл захиралагч, баригч, төлөвлөх зэрэг байгууллагуудын төлөөлөгчдийг дуудан ирүүлэх.

в/Архитектурын газрын ерөнхий архитектурын даалгавраар зөвлөлийн гишүүдээс бүх дээд байгууллагуудад төлөөлөгчөөр сууццуулана.

г/Тус зөвлөлийн ажлын туршлагыг нэгтгэн дүгнэж хэвлэн нийтлэх, зөвлөлийн хурлаас гаргасан протогол нийтлэх, зөвлөлийн хурлаас гаргасан протогол нийтлэх.

9. Архитектурын Зөвлөлийн хурлаас гарсан протоголыг тус зөвлөлийн дарга буюу түүний орлогчоор батлагдсаны дараа хүчин төгөлдөр болсонд тооцож гүйцэтгэгч ба төлөвлөгч байгууллагууд биелүүлэх үүрэгтэй болно.

4. УДИРДАГА.

Ю. Архитектурын зөвлөлийг хотын Архитектурын газрын ерөнхий архитектор удирдана. Зөвлөлийн орлогч нь архитектурын газрын орлогч дарга болно.

II. Архитектурын зөвлөлийн ажиллагаа ба зөвлөлийн төлөвлөгч байгууллагуудтай тогтмол харилцаатай байлгах

ажиллуулах явдлыг тус зөвлөлийн хариуцлагатай нарийн
бичгийн дарга гүйцэтгэнэ.

Архитектурын газар.